



## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт .....	3
Аудитын зорилт .....	4
Хамарсан хүрээ .....	4
Арга зүй .....	4
Оршил .....	5
Сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт .....	5
Нягтлан бодох бүртгэлийн хууль зөрчигджээ .....	6
Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй байна .....	6
Хүчин төгөлдөр бус шийдвэрээр зориулалт бусаар хөрөнгө зарцуулжээ .....	7
Аудитын дүгнэлт .....	9
Аудитын зөвлөмж .....	10
Холбогдох байгууллагын санал .....	11
Саналд өгсөн тайлбар .....	12
Хавсралт	



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>СЯ</b>	Сангийн яам
<b>ЭМЯ</b>	Эрүүл мэндийн яам
<b>ХЗДХС</b>	Хууль зүй, дотоод хэргийн сайд
<b>БТСУХ</b>	Биеийн тамир, спортын улсын хороо
<b>ОНБУХ</b>	Олимпийн наадамд бэлтгэх Үндэсний хороо
<b>ТАТХ</b>	Төрийн аудитын тухай хууль
<b>ТХШТХ</b>	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
<b>НББТХ</b>	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
<b>АТХ</b>	Аудитын тухай хууль
<b>ТББТХ</b>	Төрийн бус байгууллагын тухай хууль
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>АШБ</b>	Анхан шатны бүртгэл
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>ХАОАТ</b>	Хүн амын орлогын албан татвар
<b>ҮШБ</b>	Үндэсний шигшээ баг
<b>МҮОНРТ</b>	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
<b>СТО</b>	Спортын төв ордон
<b>МЧБХ</b>	Монголын чөлөөт бөхийн холбоо
<b>ААНБ</b>	Аж ахуйн нэгж, байгууллага



## **Аудитын зорилт**

УИХ-ын гишүүн Н.Баяртсайханы хүсэлтийн дагуу “Олимп хөгжил” сангийн 2006 оны 7 дугаар сарын 4-нөөс 2008 оны 6 дугаар сарын 10-ныг хүртэлх хугацааны санхүүгийн үйл ажиллагааг шалгах, санхүүгийн эрсдэлийг бууруулах, хяналтыг сайжруулах дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, сангийн үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь үндсэн чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- “Олимп хөгжил” сангийн орлогын бүрдэлт,
- “Олимп хөгжил” сангийн хөрөнгийн зарцуулалт.

## **Хамарсан хүрээ**

Аудитад “Олимп хөгжил” сангийн 2006 оноос хойшхи санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, сангийн орлогын бүрдэлт, зарцуулалттай холбогдсон аж ахуйн нэгж, байгууллага болон спортын холбоод, олон нийтийн байгууллага, банк санхүүгийн байгууллагыг хамруулав.

## **Арга зүй**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан, “Олимп хөгжил” сангийн үйл ажиллагааны талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, сангийн мөнгөн хөрөнгийн бүрдэлт, зарцуулалтын баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.



## Оршил

Монгол Улсын Ерөнхий сайдын 2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 56 дугаар захирамжаар “Олимпийн наадам”-д бэлтгэх Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг баталж, “Олимпийн наадам”-д оролцох Монголын тамирчдад дэмжлэг үзүүлэх гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хандивыг, төвлөрүүлэх үүрэг бүхий “Бээжин-2008” сан байгуулан ажиллахыг Үндэсний хороонд зөвшөөрчээ.

Олимпийн наадамд бэлтгэх Үндэсний хорооны 2006 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар Биеийн тамир, спортын “Олимп хөгжил” сангийн дүрмийг баталж, улмаар ХЗДХС-ын 2006 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 128 дугаар тушаалаар “Олимп хөгжил” сан /Цаашид “Сан” гэх/-г улсын бүртгэлд бүртгэж, Төрийн бус байгууллагын гэрчилгээ олгожээ.

“Олимп хөгжил” сангийн гүйцэтгэх захирал Ч.Наранбаатар 2006 оны 7 дугаар сараас 1 дүгээр гарын үсгийг, нягтлан бодогч М.Саранчимэг 2 дугаар гарын үсгийг зурж орлого, зарлагын гүйлгээг хийж иржээ. Тус сангийн гүйцэтгэх захирал Ч.Наранбаатар БТСУХ-ны даргаар, М.Саранчимэг тус хорооны ерөнхий нягтлан бодогчоор ажилладаг бөгөөд уг сангаас цалин, урамшуулал аваагүй байна.

### 1. Сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

“Олимп хөгжил” санд 2006 оноос 2008 оны 6 дугаар сарын 10 хүртэлх хугацаанд ААНБ, иргэдээс нийт 234.8 сая төгрөгийн хандив, дэмжлэг хуримтлагдсан байна.

Тухайлбал, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр 16,8 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр 32,0 сая төгрөг, Иргэний нисэхийн ерөнхий газар 13,1 сая төгрөгийн хандив тус тус өгчээ. Нийт хандивын 78,8 хувь нь төсвийн болон улсын байгууллагын ажиллагсдын цалин болон бусад орлогоос бүрджээ.

Д.д	Хандив өгсөн байгууллагууд	Дүн /сая төг/	Эзлэх хувь
1	Төсөвт байгууллага	88,553.9	37.7
2	УҮГ	54,403.7	23.2
3	Хувийн хэвшлийн компаниуд	33,838.7	14.4
4	УБТЗ, харьяа байгууллага	20,288.6	8.6
5	Зэвсэгт хүчний анги, салбар	21,735.4	9.3
6	Их, дээд сургуулиуд	4,460.2	1.9
7	Иргэд	11,590.3	4.9
	<b>Бүгд</b>	<b>234,870.8</b>	<b>100.0</b>

“Олимп хөгжил” сангаас нийт 142,9 сая төгрөгийг дараахь зориулалт, хувь хэмжээгээр зарцуулсан байна:

- Спортын материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээнд 4.5 хувь,

- ҮШБ-ийн хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 7.8 хувь,
- Олимпийн наадам, дэлхий, тив, үндэсний хэмжээний тэмцээнд өндөр амжилт үзүүлсэн буюу үзүүлэх магадлал өндөртэй тамирчдад дэмжлэг үзүүлэхэд 48.4 хувь,
- Спортын шинжлэх ухааны дэвшилтэд аргыг нэвтрүүлэх, спортын анагаах ухааныг хөгжүүлэх, тамирчдын сэтгэл зүйн бэлтгэл хангахад туслалцаа үзүүлэх арга хэмжээнд 10.5 хувь,
- Бусад зардалд 28.7 хувийг тус тус зарцуулсан байна.

Олимп хөгжил сангийн зарлагын гүйлгээний товчоо (мян.төг)

Д.д	Зардлын зүйл	Дүн
1	Спортын материаллаг баазыг бэхжүүлэх,	6,500.0
2	ҮШБ-ийн хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслэл, нэмэлт бүтээгдэхүүн худалдан авах,	11,150.4
3	Олимпийн наадам дэлхий, тив, үндэсний хэмжээний тэмцээнд өндөр амжилт үзүүлсэн буюу үзүүлэх магадлал өндөртэй тамирчдад дэмжлэг үзүүлэх, /Шүүгч, дасгалжуулагчид олгосон зардал, тэтгэлэг, дэмжлэг, эмчилгээний болон бусад зардлыг оруулан тооцов/	69,277.8
4	Спортын ШУ-ны дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, спортын анагаах ухааныг хөгжүүлэх, тамирчдын сэтгэл зүйн бэлтгэлийг хангахад туслалцаа үзүүлэх /Ном сэтгүүл хэвлэх, худалдан авах, энэхүү чиглэлийн томилолт бусад зардлыг оруулан тооцов/	14,982.5
5	Бусад	41,071.3
	<b>Бүгд</b>	<b>142,982.0</b>

“Олимп хөгжил” сангийн харилцах данс СТО-ны байранд байрлах “ХААН” банкинд байршдаг бөгөөд харилцах дансны хуулгаар нийт 68 зарлагын гүйлгээний 20 нь буюу бүгд 7,269.2 мянган төгрөгийн залруулах бичилт гарсан байна. Иймд харилцагч банкны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, нэмэлт тодруулга авлаа.

## 2. Нягтлан бодох бүртгэлийн хууль зөрчигджээ

“Олимп хөгжил” сангийн санхүүгийн тайлан тэнцлийг 2006-2008 онуудад гаргаагүй бөгөөд энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 1<sup>1</sup>, “Төрийн бус байгууллагын тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 1<sup>2</sup>, Сангийн сайдын 2005 оны 385 дугаар тушаалаар баталсан “Төрийн бус байгуулагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Олимп хөгжил” сангийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 3 дахь<sup>3</sup> заалтуудыг зөрчсөн байна.

<sup>1</sup> “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, түүний эх үүсвэр болон үйлдвэрлэл, ажил, үйлчилгээнийхээ санхүүгийн үр дүн, мөнгөн хөрөнгийн хөдлөлийн талаар нягтлан бодох бүртгэл заавал хөтөлж, тайлан тэнцэл гаргана”

<sup>2</sup> “Төрийн бус байгууллага нь зохих журмын дагуу жилийнхээ тайлан тэнцлийг гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор Татварын албанд өгнө”

<sup>3</sup> “Сангийн тайлан тэнцлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргаж, Сангийн Удирдах зөвлөлд хагас жилд нэг удаа танилцуулан, хандивлагч байгууллага аж ахуйн нэгж, иргэдэд болон олон нийтэд заавал мэдээлэх”



“Олимп хөгжил” сангийн харилцах данснаас зарлага болгосон 48 удаагийн гүйлгээнээс 3 удаагийн 53.5 сая төгрөгийн гүйлгээг бэлэн бус хэлбэрээр, 138.4 сая төгрөгийн гүйлгээг зарлагын мэдүүлгээр бэлнээр авч зарцуулсан байна. Сангийн данснаас бэлэн мөнгөөр зарлага болгохдоо мөнгөн кассаар дамжуулалгүй нягтлан бодогч М.Саранчимэг өөрөө хүлээн авч байгууллага, иргэдэд бэлнээр олгож байсан нь доорхи хуулийн заалтуудыг зөрчсөн байна:

- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.2 : “Өөрийн ажил үүргийн дагуу шууд хяналт тавьдаг албан тушаалын ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно”*
- *Сангийн сайдын 2005 оны 123 дугаар тушаалаар баталсан “Мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6: “Мөнгөн кассын тооцооны ажилтай шууд холбогдол бүхий нягтлан бодогч зэрэг хүмүүсийг мөнгөн кассын нярвын ажлыг давхар гүйцэтгүүлэхийг хориглоно”*

### 3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалтгүй байна

БНСУ-ын Инчон хотын биеийн тамирын байгууллагаас хандив, тусламжаар олгосон 41,753.00 ам.доллар буюу 48,876,896.00 төгрөгийн үнэ бүхий 25 хүний суудалтай автобус, 2,890,500.00 төгрөгийн тавилга, эд хогшил, бүгд 51,767,396.00 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө...нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” гэж заасныг зөрчсөн байна. */Энэ зөрчлийг арилгуулах, нягтлан бодох бүртгэлд тусгуулах албан шаардлага өглөө/*

### 4. Хүчин төгөлдөр бус шийдвэрээр зориулалт бусаар хөрөнгө зарцуулжээ

- МҮОНТ-тэй гэрээгээр хамтран ажилладаг Ө.Нарангэрэл захиралтай хувийн “Чандмань студи”-д тухайн байгууллагын албан бичгийг үндэслэн камер авах зориулалтаар 4,254.4 мянган төгрөг нягтлан бодогч Л.Эрдэнэтуяад бэлнээр олгосон байна. Энэ мөнгийг буцаан төлүүлэх нь зүйтэй гэж үзэв. */Энэ гүйлгээтэй холбогдолтой материалыг тодруулах гэсэн боловч нягтлан бодогч Л.Эрдэнэтуяа үзүүлэхээс эрс татгалзсан/*
- “NTV” хувийн телевизийн зураглаач З.Мөнхзол, найруулагч Ж.Баярбаатар нарын гадаад томилолтын зардалд 4.498.3 мянган төгрөгийг /Ч.Наранбаатарын гарын үсэг зурсан цагаан цаасан дээр он, сар, өдөр, дугаар байхгүй шийдвэрээр/ олгожээ. */Азербайджан улсын нийслэл Баку хотод болсон чөлөөт бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг сурвалжлан, сургалтад ашиглах тэмцээний бичлэг хийж бэлтгэл сургуулилтанд ашиглаж байгаа гэсэн тайлбар өгч байна/.*
- ҮШБ-ийн тамирчдын 2007 оны шинэ жилийн арга хэмжээнд зориулж /Ч.Наранбаатарын гарын үсэгтэй он, сар, өдөр, дугааргүй тушаалтай/ бүгд 8,083.2 мянган төгрөгийг сангийн хөрөнгөөс зарцуулсан байна.



- БТСУХорооны дэд дарга Д.Сүрэнхорлоо, ҮШБ-ийн албаны дарга Н.Оюунбат, мэргэжилтэн Б.Энхбаатар нарын БНХАУ-д ажиллах гадаад томилолтын зардал 1,832.6 мянган төгрөгийг БТСУХ-ноос гаргалгүй “Олимп хөгжил” сангаас зарцуулжээ.

Олимпийн наадамд бэлтгэх Үндэсний хорооны 2006 оны 7 дугаар сарын 4 -ний өдрийн 4 дүгээр тогтоолоор Сангийн удирдах зөвлөлийн даргаар Сангийн сайд Н.Баяртсайханыг, гишүүдээр нь УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Ламбаа, Эрүүл мэндийн дэд сайд А.Отгонболд, Ерөнхий сайдын зөвлөх Б.Долгор, Монгол банкны ерөнхийлөгч О.Чулуунбат, “УБТЗ” ХНН-ийн дарга В.Отгондэмбэрэл, МҮОХ-ны ерөнхийлөгч Д.Загдсүрэн, “Петровис” ХХК-ийн ерөнхийлөгч Ж.Оюунгэрэл, “Зоос” банкны ТУЗ-ийн дарга Б.Батбаяр, “Мобиком” корпорацийн Олон нийттэй харилцах албаны дарга Д.Болор нарыг баталжээ. Сангийн удирдах зөвлөл 2006-2008 онд нэг ч удаа хуралдаагүй, тус зөвлөл үндсэндээ үүргээ биелүүлээгүй байна.

“Олимп хөгжил” сангийн удирдах зөвлөлийн дарга Н.Баяртсайханы зөвшөөрлөөр эргэн төлөгдөх нөхцөлөөр 2 сарын хугацаатай боловч гэрээ хэлцлээр баталгаажуулаагүй, хүүгийн төлбөргүйгээр 48.0 сая төгрөгийг 2007 оны 3 дугаар сарын 13-ны өдөр МЧБХ-нд олгосон бөгөөд тус холбоо уг мөнгийг 11 дүгээр сарын 12-ны өдөр буцааж тушаажээ. Энэ нь “Олимп хөгжил” сангийн дүрмийн 4.16-д “*Сангийн хөрөнгийг ...зээлээр ашиглах буюу ашиглуулах, энэ дүрэмд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно*” гэж заасныг зөрчжээ.

“Олимп хөгжил” сантай гэрээгээр ажиллагсдын ажлын хөлс, урамшууллаас 911.5 мянган төгрөгийн хүн амын орлогын албан татварыг суутгаж, төсөвт шилжүүлээгүй нь “Хүн амын орлогын албан татварын хууль”-ийн холбогдох заалтыг зөрчжээ.

Мөн “Олимп хөгжил” сангийн гүйцэтгэх захирлын гаргасан тушаалын бүртгэл байхгүй, дурын дугаар бичдэг, зарим тушаал албан бланк дээр бус, он, сар, өдөр, дугааргүй, тамга тэмдэг дараагүй гэх мэт зөрчилтэй, албан бичгийн бүртгэл хөтлөгдөөгүй байна.

Тус сан аудитын явцад зарлагын гүйлгээтэй холбогдсон баримт материал дутуу, мөнгө хүлээн авсан баримтад гарын үсэг зураагүй бүгд 31 ширхэг, 68.2 сая төгрөгийн баримтыг нөхөн бүрдүүлсэн тухай 2008 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ҮАГ-т мэдэгдэв.

## 5. Дүгнэлт

“Олимп хөгжил” сангийн 2006-2008 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- “Олимп хөгжил” сангийн харилцах дансанд 2006-2008 онд давхардсан гүйлгээгээр бүгд 291.1 сая төгрөгийн орлогын, 199.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 91.8 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй гарсан байхад нэг ч удаа тайлан тэнцэл гаргаагүй нь НББ-ийн тухай, ТББ-ын тухай хууль болон сангийн дүрмийг зөрчсөн байна.
- “Олимп хөгжил” сангаас 45 удаагийн 138.4 сая төгрөгийн гүйлгээг зарлагын мэдүүлгээр бэлнээр хүлээж авч, зарлага болгохдоо мөнгөн кассаар дамжуулалгүй нягтлан бодогч М.Саранчимэг өөрөө хүлээн авч байгууллага, иргэдэд олгосон ба ихэнх гүйлгээнд мөнгө хүлээж авсан хүний гарын үсэг байхгүй, мөнгөн кассын орлого зарлагын тайлан гаргаагүй нь Сангийн сайдын 2005 оны 123 дугаар тушаалаар баталсан “Мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг зөрчжээ.
- Сангийн удирдах зөвлөлд төрийн болон төрийн бус байгууллага, бизнесийн төлөөлөгчид байгаа боловч эдгээр хүмүүсээс бүрдсэн зөвлөл 2006-2008 онд нэг ч удаа хуралдаагүй, хандив, тусламжийн хөрөнгийг зарцуулах талаар шийдвэр гаргаагүй байна. “Олимп хөгжил” сангийн гүйцэтгэх захирлын гаргасан тушаалын бүртгэл байхгүй, зарлага болгох тушаалуудад дугаар, он, сар, өдөр байхгүй, тамгагүй бүрэн бус шийдвэрээр зарлага болгож байжээ.
- Сангийн хөрөнгөөс Удирдах зөвлөлийн шийдвэргүйгээр хувийн телевиз, студид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шинэ жилийн арга хэмжээнд зарцуулах, БТСУХ-ны ажиллагсдын гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх, ямар ч хүүгүй зээлийг удаан хугацаагаар олгох зэрэг “Олимп хөгжил” сангийн дүрмийн заалтыг зөрчиж зориулалт бусаар нийт 66.6 сая төгрөгийг зарцуулжээ. Мөн бусдад олгосон ажлын хөлс, урамшууллаас 911.5 мянган төгрөгийн хүн амын орлогын татварыг суутган тооцоогүй нь ХАОАТ-ын хуулийг зөрчсөн байна.
- Хандив, тусламжаар олгосон 25 хүний суудалтай автобус, тавилга эд хогшил зэрэг бүгд 51.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, тайлан тэнцэл гаргаагүй байна.





## 6. Зөвлөмж

Аудитын дүнг үндэслэн дараахь зөвлөмжийг өгч байна:

“Олимп хөгжил” сангийн удирдах зөвлөлийн дарга Ч.Улаан-д

- “Олимп хөгжил” сангийн удирдах зөвлөлийн хурлаар дээрх зөрчил, дутагдлыг хэлэлцэж, дүрэмд заасны дагуу холбогдох арга хэмжээ авах.

“Олимп хөгжил” сангийн гүйцэтгэх захирал Ч.Наранбаатар-т

- Сангийн 2006-2008 оны санхүүгийн тайлан тэнцлийг нөхөн гаргуулах ажлыг зохион байгуулах;
- “Мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах;
- Сангийн хөрөнгийг хууль тогтоомж, сангийн дүрэмд зааснаас өөр зүйлд зарцуулахгүй байх.



“Олимп хөгжил” сангаас ирүүлсэн санал:



ОЛИМП ХӨГЖИЛ САН

210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 55, Утас: 32-10-02, 32-53-22, Факс: 32-52-34  
E-mail: sportorg@mongolnet.mn

2008 09 09 № 16  
танай 2008 09 09 -ны № 3/292 -т

Санал хүргүүлэх тухай

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА Л. ЖАВЗМАА ТАНАА

ҮАГ-ын тайлбар  
1-ийг үзнэ үү.

Монгол улсын Үндэсний Аудитын газраас “Олимп хөгжил” сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад, дараах саналыг хүргүүлж байна.

Тайланд дурдагдсан зөвлөмж, дүгнэлтүүдийг хүлээн зөвшөөрч, зөрчил доголдлыг тогтоосон хугацаанд нь арилгаж, цаашид давтахгүй байх талаар анхааран ажиллах болно.

Сангийн санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд гарсан зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрч байгаа боловч сангийн үйл ажиллагааг дагнан хариуцаж ажиллах гэрээт ажилтан авах тухай саналыг “Олимп хөгжил” сангийн удирдах зөвлөлд тависан боловч асуудал шийдэгдээгүйн улмаас БТСУХ-ны үндсэн ажилтнууд ажлын хажуугаар албан бусаар хийдэг байсан нь дээрх зөрчил дутагдлыг гарахад нөлөөлсөн. Бид шалгалтын явцад дээрх дутагдлыг засаж, 2006-2008 оны эхний хагас жилийг дуустал хугацааны санхүүгийн тайланг гаргаж, хөрөнгийг орлогод авсан тул нүүр хуудсанд томоор тависан өгүүлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Санхүүгийн тайлан гаргаагүй, нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй гэсэн дүгнэлтийг бичихдээ “Албан ёсоор хариуцаж ажилладаг ажилтан байхгүй улмаас дээрх зөрчил доголдол гарсан байна” гэж утга найруулгын хувьд өөрчлөх хүсэлтэй байна.

Бидний хүчин чармайлтын үр дүнд Олимп хөгжил санд 237 сая төгрөг бэлнээр, 63 сая төгрөгийн үндсэн хөрөнгө биетээр, 13.3 сая төгрөгийн материал биетээр, нийт 313.3 сая төгрөгийн хандив тусламжийг төвлөрүүлж, биеийн тамир спорт тэр дундаа ҮШБ-ийн үйл ажиллагааг дэмжихэд зарцуулсан билээ.

Дээрх хандив тусламжаас “Олимп хөгжил” санд Солонгос улсын Сөүл хотын Инчон дүүргээс бэлэглэсэн 25 хүний суудалтай, 48.9 сая төгрөгийн үнэтэй автобус нь тамирчдад унаагаар үйлчлэх ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн.

Бид өнөөдрийг хүртэл энэ ажлыг хийсний төлөө ямар нэгэн шагнал урамшуулал, цалин аваагүй бөгөөд энэ ажлыг хийхэд маш их цаг хугацаа хүч хөдөлмөр зарцуулсан.

Иймээс 66.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан гэсэн дүгнэлт хийснийг хүлээн зөвшөөрөхгүй байна.

66.6 төгрөгийг шууд болон шууд бусаар биеийн тамир спортыг дэмжихэд зориулсан бөгөөд энэ мөнгө нь Олимпын наадмаас медальтнууд төрж, дэлхийн дэвжээнд эх орныхоо нэрийг дуурсгаж, ард түмнээ баясгахад бодит хувь нэмрээ оруулсан.

Бидний ажилд зөвлөмж өгч, хамтран ажилласан танд болон танай хамт олонд талархалаа илэрхийлье.



Таныг хүндэтгэсэн :

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.НАРАНБААТАР



## **Олимп хөгжил сангаас ирүүлсэн саналд өгөх тайлбар:**

### **ҮАГ-ын тайлбар 1**

“Олимп хөгжил” сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг удирдах, хөтлөн явуулах эрх, үүргийг хамаарсан тодорхой албан тушаалтан өнгөрсөн хугацаанд ажиллаж ирснийг аудитын тайланд тэмдэглэсэн бөгөөд тус сангийн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд ч гэсэн ҮАГ-аас шүүмжлэлтэй хандсан байна. Иймд аудитын тайланд засвар хийх шаардлагагүй юм.

### **ҮАГ-ын тайлбар 2**

Аудитын дүгнэлт хэсэгт “Олимп хөгжил” сангийн дүрмийн заалтыг зөрчиж, зориулалт бус зардлыг санхүүжүүлсэн талаар дурдсан байна. Цаашид эдгээр зөрчил дутагдлыг давтан гаргахгүй ажиллах ёстой. Иймд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.



**ОЛИМП ХӨГЖИЛ САН**

210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 55, Утас: 32-10-02, 32-53-22, Факс: 32-52-34  
E-mail: sportorg@mongolnet.mn

2008.06.25 № 11  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Үндэсний аудитын газарт

Манай байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийж байгаа аудитын ажлын явцад нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу хийгдсэнийг нөхөн бүрдүүлж хавсралаар хүргүүлэв.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.НАРАНБААТАР



Олимп хөгжил сангийн санхүүгийн баримтыг нөхөн бүрдүүлсэн жагсаалт

№	Мөнгөн дүн	Тайлбар
1	2,930,790	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
2	42,200	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн. Зарлагын баримт бүрдүүлсэн.
3	2,000,000	Мөнгө тушаасан баримт, мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
4	100,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
5	105,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
6	66,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
7	150,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
8	84,500	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
9	1,494,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
10	3,000,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
11	506,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн. Зарлагын баримт бүрдүүлсэн.
12	105,700	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
13	160,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
14	1,000,000	Гэрээ нөхөн хийсэн.
15	390,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
16	180,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
17	2,009,815	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
18	1,710,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
19	72,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн. Зарлагын баримт бүрдүүлсэн.
20	7,000,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
21	5,925,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
22	25,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн. Зарлагын баримт бүрдүүлсэн.
23	6,500,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн. Зарлагын баримт бүрдүүлсэн.
24	1,422,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
25	2,424,510	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
26	5,925,000	Гэрээг олж хавсаргасан.
27	2,890,000	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн
28	13,524,480	Тийзийн баримтуудыг нэрсийн жагсаалтын хамт хавсаргасан.
29	1,170,000	Уралдаан дүгнэсэн актыг хавсаргасан.
30	327,400	Мөнгө хүлээн авсан баримтыг нөхөн бүрдүүлсэн. Зарлагын баримт бүрдүүлсэн.
31	5,000,000	Сангийн удирдах зөвлөлийн шийдвэр гаргуулсан.
дүн	68,239,395	

Жагсаалт гаргасан

М.Саранчимэг